



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2022/12/НА-СТА-ТТЗ

|                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|-----------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Даланзадгад хот<br>2022 он | Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn<br><br>Аудитор: С.Одончимэг<br>Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn |
|-----------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Х.НЭХИЙТ ТАНАА

2022.03.24 № 283  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ханбогд сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ханбогд сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.ЦЭРЭНБАЯА

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-03-24 №283г

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

сая төгрөгөөр/

|                                                | Үзүүлэлт                                          | 2020.12.31        | 2021.12.31        |
|------------------------------------------------|---------------------------------------------------|-------------------|-------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                   |                   |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 5,962.90          | 3,345.40          |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 41,078.10         | 50,206.70         |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>47,041.00</b>  | <b>53,552.10</b>  |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | <b>1,114.30</b>   | 3,791.60          |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 45,926.70         | 49,760.50         |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>47,041.00</b>  | <b>53,552.10</b>  |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                   |                   |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 19,864.60         | 15,044.10         |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 15,030.90         | 13,918.10         |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>4,833.70</b>   | <b>1,126.00</b>   |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | 1,666.00          | 1,666.70          |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>3,167.70</b>   | <b>- 540.70</b>   |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                   |                   |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 45,926.60         | 50,301.20         |
|                                                | Тайлант оны үр дүн                                |                   | - 540.70          |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>45,926.60</b>  | <b>49,760.50</b>  |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                   |                   |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 19,449.60         | 11,989.80         |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 17,032.90         | 11,123.90         |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>2,416.70</b>   | <b>865.90</b>     |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>- 1,735.00</b> | <b>- 3,686.40</b> |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 |                   |                   |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>681.70</b>     | <b>- 2,820.50</b> |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 3,861.20          | 4,542.90          |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | <b>4,542.90</b>   | <b>1,722.20</b>   |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   |                   |                   |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>10,565.50</b>  | <b>8,717.00</b>   |
|                                                | Урсгал зардал                                     | 6,324.10          | 5,485.30          |
|                                                | Хөрөнгийн зардал                                  | 4,241.40          | 3,231.70          |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>10,565.50</b>  | <b>7,758.90</b>   |
|                                                | Улсын төсвөөс санхүүжих                           | 4,350.40          | 4,217.40          |
|                                                | Орон нутгийн төсвөөс санхүүжих                    | 4,824.70          | 3,391.30          |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих   | 1,321.30          | 137.30            |
|                                                | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих      | 69.10             | 12.90             |

## **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Ханбогд сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн сумынхаа хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл зүрхээ зориулан ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, шадар туслагч нь байхад эрхэм зорилго оршино” гэж тодорхойлжээ.

Тайланд онд дараах зорилтуудыг тавин ажилласан байна. Үүнд:

- Орон нутгийн захиргааны байгууллагын бодлого, шийдвэр, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны ил тод байдал, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэн бүрд хүрсэн шуурхай үйлчилгээг бий болгох
- Хүний хөгжлийг дэмжсэн улс орон нутгийн бодлого зорилтыг хэрэгжүүлж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хүний хөгжлийг бүх талаар дэмжих
- Сумын хөгжлийн хэтийн бодлогыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлж, эдийн засаг, дэд бүтцийн зохистой харьцааг бий болгох замаар орон нутгийн хөгжлийг хангах
- Байгаль экологийн тэнцвэрт байдлыг ханган хөдөө аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх замаар иргэдийн амьдрах эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх
- Авлигын эсрэг хууль, Батлах хамгаалах Гамшгаас хамгаалах тухай хууль, ГХУС тухай хуулийн хэрэгжилтийг хангах төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг хангах зорилтуудыг тавин ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаал
- “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал
- “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол

## **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахалтай холбоотойгоор өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж орон нутгийн нөөц хөрөнгөөс болон ЗДТГ-ын төсвөөс 146.3 сая төгрөгийн өртөг бүхий ариутгалын бодис, хамгаалах хувцас, хэрэглэл, тээвэр шатахуун, хоол, урамшууллын зардал гаргасан байна.

## **Дөрөв. Аудитын гол асуудал**

Тайлант онд ОНТХО-аар 25 ажил, ОНХС-ийн хөрөнгөөр 3 ажил хийгдсэн бөгөөд тухайн ажлуудыг данс бүртгэлд тусгаж ажилласан ч барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, эд хогшлын чанар, хэрэгжилтийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэлт өгөх боломжгүй байлаа.

## **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

### **5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ОНХС-ийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцруулж мэдээлсэн, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, тусгай сангаас хөрөнгө зарцуулсан нийт 47.8 сая төгрөгийн үнийн дүнтэй 5 шийдвэрийг тус тус мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.5, 6.4.8-д заасантай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн гүйцэтгэлийн аудитаар 2021 онд хийгдсэн хөрөнгө оруулалтыг нүдээр үзэж, хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

### Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 4,849.1 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс, 3,468.3 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 38.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,342.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

### 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТТЗ                         | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>1</b>                 | <b>1</b>                    |                    |                 | <b>1</b>                |                |       |                            |

### 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн ангилал                                                 | Нийт алдаа, зөрчлийн |                | Үүнээс    |                |               |     |                 |             |          |                |
|-----|------------------------------------------------------------------|----------------------|----------------|-----------|----------------|---------------|-----|-----------------|-------------|----------|----------------|
|     |                                                                  |                      |                | Залруулга |                | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |             | Зөвлөмж  |                |
|     |                                                                  | Тоо                  | Дүн            | Тоо       | Дүн            | Тоо           | Дүн | Тоо             | Дүн         | Тоо      | Дүн            |
| 1   | Санхүүгийн тайлангийн аудитаар                                   | 6                    | 4,801.3        | 3         | 3,468.3        |               |     | 1               | 38.8        | 2        | 1,294.2        |
| 2   | Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 1                    | 47.8           |           |                |               |     |                 |             | 1        | 47.8           |
| 3   | <b>Нийт дүн</b>                                                  | <b>7</b>             | <b>4,849.1</b> | <b>3</b>  | <b>3,468.3</b> |               |     | <b>1</b>        | <b>38.8</b> | <b>3</b> | <b>1,342.0</b> |